| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 12 | -2.00 |

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөг/**

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Тайлант оны Гүйцэтгэл | Тайлант оны Зөрүү |
|---|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **851,450,602.00** | **-851,450,602.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **851,450,602.00** | **-851,450,602.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 822,519,637.40 | **-822,519,637.40** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 35,028,493.00 | **-35,028,493.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,278,600.00 | **-2,278,600.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 26,441,263.00 | **-26,441,263.00** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 3,633,630.00 | **-3,633,630.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,675,000.00 | **-2,675,000.00** |
| **2105** | **Нормативт зардал** | | 207,027,044.40 | **-207,027,044.40** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 207,027,044.40 | **-207,027,044.40** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,637,900.00 | **-1,637,900.00** |
| 210604 | Урсгал засвар | | 1,637,900.00 | **-1,637,900.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 6,426,000.00 | **-6,426,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 6,426,000.00 | **-6,426,000.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 567,780,200.00 | **-567,780,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 567,780,200.00 | **-567,780,200.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 4,620,000.00 | **-4,620,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 4,620,000.00 | **-4,620,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 28,930,964.60 | **-28,930,964.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 600,000.00 | **-600,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 600,000.00 | **-600,000.00** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **28,330,964.60** | **-28,330,964.60** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 28,330,964.60 | **-28,330,964.60** |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 851,450,602.00 | **-851,450,602.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 851,450,602.00 | **-851,450,602.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 600,104,600.00 | **-600,104,600.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 228,986,002.00 | **-228,986,002.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 22,360,000.00 | **-22,360,000.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал, амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгааг хангах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад орчин үеийн шинжлэх ухааны онол арга зүйд тулгуурласан үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Увс аймгийн Мал эмнэлгийн газар нь Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 42 багц ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг баталж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгө үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ажлын хэсэг нь Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2020, 2021, 2022 оны эхний хагас жилийн санхүү аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн байна. Шалгалтаар Төсвийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ, Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж, батлагдсан орон тоогоор ажиллаагүй байна гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,703.0 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 3,575.0 | 6,835.8 | 3,260.8 |
| Бараа материал | 169,624.4 | 164,324.9 | -5,299.5 |
| Үндсэн хөрөнгө | 348,073.8 | 350,609.5 | 2,535.7 |
| **Нийт хөрөнгө** | **528,473.2** | **521,770.2** | **-6,703.0** |
| Өр төлбөр | 132.5 | 92,306.9 | 92,174.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 528,340.7 | 429,463.3 | -98,877.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **528,473.2** | **521,770.2** | **-6,703.0** |

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 6,835.8 мянган төгрөг болж 3,260.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 164,324.9 мянган төгрөг болж 5,299.5 мянган төгрөгөөр буурсан нь малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан вакцин, эм боох материалын зардал их гарснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 350,609.5 мянган төгрөг болж 2,535.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй барилга байгууламж нэмэгдсэн, тайлант онд 101,078.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 92,306.9 мянган төгрөг болж 92,174.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс малын гоц халдварт өвчний үйлчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 429.463.3 мянган төгрөг болж 98,877.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,077,840.4 мянга, үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга, нийт зарлагыг 1,078,840.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15,000.0 мянган төгрөгөөр бууруулж 792.066.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 15,107.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 788,876.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 788,876.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 786,714.9 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 70,795.8 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх 80101-Үндсэн үйл ажиллагаа | 459,253.3 | 417,800.9 | 37,452.4 | 91% |
| 2 | 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх 82504-Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 205,780.0 | 203,487.0 | 2,293.0 | 98.9% |
| 3 | 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх 82507-Малын архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх | 148,491.0 | 145,759.5 | 2,735.1 | 98.2% |
| 4 | 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх 82510-Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэл | 17,000.0 | 17,000.0 | 0.0 | 100% |
| 5 | 70805-Мал аж ахуйг хөгжүүлэх 80101-Үндсэн үйл ажиллагаа | 247,019.1 | 218,922.8 | 27,466.8 | 88.6% |
| 6 | 70805-Мал аж ахуйг хөгжүүлэх 80227-Лаброторын итгэмжлэл | 303.1 | 0 | 303.1 | 0 |
| 7 | 70805-Мал аж ахуйг хөгжүүлэх 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 21,474.4 | 20,929.0 | 545.4 | 97.5% |

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэн нь сумдын тархвар зүйчийн орон тоонд ажилтан томилогдоогүй, дутуу ажиллаж байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 600,104.6 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 228,986.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,360.0 мянга, нийт 851,450.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. /шүүхийн шийдвэрийн торгууль 22,360.0 мянган төгрөг/

Үүнээс хангамж, бараа материалын зардал 35,028.5 мянга, норматив зардалд 207,027.0, эд хогшил урсгал засварын зардал 1637.9 мянга, томилолтын зардалд 6,426.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардалд 567,780.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 4,620.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 600.0 мянга, нийт 823,119.6 мянган төгрөгийг зарцуулж, 28,331.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,812.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,931,090.9 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 14,655.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,724.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 141, хугацаа хоцроосон 21 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг Увс аймгийн Мал эмнэлгийн газар нь тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар Төсвийг зохистой удирдаж заагдсан орон тоог хэтрүүлэхгүй байх* зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | |
| Албан шаардлага | - | - | - | - | |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 0 | 0.0 | |
| **Нийт дүн** | 1 | 0.0 | 0 | 0.0 | 0% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувийн Мал эмнэлгийн нэгжүүд, сумын Засаг даргын тамгын газартай гурвалсан гэрээ байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хөлс олгож байна. Иймд гэрээний хэрэгжилт, үр дүнг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,844.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 14,844.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

### 5.2 Албан шаардлага

1. Увс аймгийн Мал эмнэлгийн газар нь жолооч /ариутгал халдваргүйтгэл, сантехникч/, лаборант /үйлчлэгч/ гэсэн бүтэц, орон тоог хэтрүүлэн 1 үйлчлэгч, 1 жолооч ажиллуулан 14,844.5 мянган төгрөгийн цалинг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 6.6.2-т "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2 дахь заалтад "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт "шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр

тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

## 1. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Мал эмнэлгийн газар нь Шилэн дансны цахим хуудсанд 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Увс аймгийн Мал эмнэлгийн газар нь жолооч /ариутгал халдваргүйтгэл, сантехникч/, лаборант /үйлчлэгч/ гэсэн бүтэц, орон тоог хэтрүүлэн 1 үйлчлэгч, 1 жолооч ажиллуулан 14,844.5 мянган төгрөгийн цалинг олгосон | 1 | 14,844.5 | | | 1 | 14,844.5 | | | | | | |
| Дүн | 1 | 14,844.5 | 0 | 0 | 1 | 14,844.5 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ч.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТАМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Б.ОДГЭРЭЛ/

2023 оны 02 сарын 24-ний өдөр

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 24 өдөр | Дугаар 01/20/А0070417 УВА-2023/85/НА-СТА-ТШ3 | Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мал эмнэлгийн газар нь жолооч /ариутгал халдваргүйтгэл, сантехникч/, лаборант /үйлчлэгч/ гэсэн бүтэц, орон тоог хэтрүүлэн 1 үйлчлэгч, 1 жолооч нэмж томилон төсвөөс 14844542 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 6.6.2-т "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах үйлсийг хориглоно", 15.1.2 дахь заалтад "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт "шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10 дахь заалтад "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар[2]т ируүлэх.

---

[2]*Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317*

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга Д.Ганхуяг, нягтлан бодогч Ч.Баясгалан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР Б.ОДГЭРЭЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ